



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 90

Номгон

Ламын гэгээний улаан тэмээний  
үржил селекцийн цаашдын бодлого  
/стратеги/-ыг батлах тухай

Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.4.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ламын гэгээний улаан тэмээний үржил селекцийн цаашдын бодлого /стратеги/-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан стратегийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117213

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын  
31-ний өдрийн 90 дүгээр тогтоолын хавсралт

ЛАМЫН ГЭГЭЭНИЙ УЛААН ТЭМЭЭНИЙ ҮРЖИЛ  
СЕЛЕКЦИЙН ЦААШДЫН БОДЛОГО /СТРАТЕГИ/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуучнаар Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний хошуу одоогийн Баянхонгор аймгийн Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь сумын нутагт эрт дээр үеэс гэгээнтний сүрэг хэмээн жижгэвтэр биетэй, тэсвэр хатуужил, бяр чадал, сүүний гарц сайтай улаан тэмээ өсгөн үржүүлж орон нутагтаа болон гадагшаа жин, тээвэр хийж байсан бөгөөд өнөөг хүртэл дээрх сумдад ялангуяа Баянлиг, Богд суманд цөм сүрэг бүрдүүлэн үржүүлж байна.

1970-д оноос тэмээгээ сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх чиглэлээр айл саахалт, баг, сум хооронд улмаар өөр аймаг, сумаас буур, ингэ авчрах, солилцох байдлаар ардын селекцийн аргаар үржлийн ажил явуулж ингэний сүү бэлтгэх, цагаан идээ боловсруулахын тулд зарим сумд ингэний ферм, үржлийн шилмэл тэмээний суурь зохион байгуулах ажил хийгдэж байв.

Тэмээний ноосны гарцыг нэмэгдүүлэх, бие цогцосыг нь томруулахын тулд Өмнөговь, Говь-Алтай аймгаас буур авчрах, орон нутгийн тэмээн сүрэгт ангилалт, шилэн сонголт хийх, үржил селекцийн ажлыг төлөвлөгөөтэй тасралтгүй явуулахад тухайн үеийн нэгдэл, бригадын зоотехникч нар малчидтай хамтран идэвхтэй ажиллаж байсны дээр 2000-д оноос урьд нь хийгдэж байсан үржлийн ажлыг үргэлжлүүлж шинжлэх ухааны үндэслэлтэй болгон хэрэгжүүлж ирсний үр дүнд одоо энэ тэмээ үүлдрийн хэмжээнд хүрчээ.


Тус аймгийн нийт тэмээн сүргийн 65 орчим хувь нь Ламын гэгээний улаан тэмээ бөгөөд жилд дундажаар 3800 ботго буюу аймгийн нийт ботгоны 63,7 хувийг бойжуулж тэмээний ноос, мах, сүүний 60-аас доошгүй хувийг бэлтгэж байна. Одоогийн байдлаар тэмээн сүрэгт жил бүр ангилалт, шилэн сонголт, ашиг шимийн гарц тогтоох, мал эмнэлгийн арга хэмжээнд хамруулах, эдийн засгийн тооцоо гаргах зэрэг ажлыг аймаг, сумын мэргэжилтнүүд, малчдын оролцоотой зохион байгуулж тэмээчид малчдын дунд зөвөлгөөн, өдөрлөг, уралдаан тэмцээн хийж байна.

Ламын гэгээний улаан тэмээний цөм сүрэг нь Баянлиг, Богд сумд байгаа бөгөөд үржил селекцийн ажлын ихэнх хувийг эдгээр сумдад явуулж Баянговь, Жинст, Өлзийт сумдад ч зарим ажил хийгдэж байна.

Энэ тэмээг үржлийн хэсгээр батлуулахаар арга зүйн дагуу үржил селекц, судалгаа шинжилгээний ажлыг сүүлийн 10-аад жил эрчимтэй явуулж ХХААХҮЯ-аас байгуулагдсан

ажлын хэсэг, холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүд сум орон нутагт ирж танилцан мэргэжлийн дүгнэлт гаргаад байна.

Ламын гэгээний улаан тэмээг одоогоор үржлийн хэсгийн шаардлага хангасан гэж үзэж байгаач УИХ-д өргөн баригдсан “Малын генетик нөөцийн тухай” хуулинд үржлийн хэсэг, үүлдрийн хэсэг гэсэн ойлголтыг байхгүй болгосон тул омгоор цаашид үүлдрээр батлуулах хэмжээнд хүрсэн гэж үзэж байна.



### ХОЁР. ЗОРИЛГО

Тэмээний тоо толгойг нэмэгдүүлэх, ашиг шимийн чанарыг сайжруулах чиглэлээр өөр дотор нь цэврээр үржүүлэхийн зэрэгцээ сайжруулагчаар ашиглах бодлогын хүрээнд үржил селекцийн ажлыг системтэй, тодорхой төлөвлөгөөтэй, зохион байгуулах улмаар нэгжээс ашиглах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж аймаг орон нутаг, малчдын орлогыг өсгөхөд чиглэгдэнэ.

### ГУРАВ. ЗОРИЛТ

3.1 Малын үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, нэгж, мэргэжилтнүүдийн чадавхыг нэмэгдүүлэх.

3.2 Үржил селекцийн ажлын хүртээмж чанарыг сайжруулах, тэмээний тоо толгойг тогтвортой өсгөх.

3.3 Тэмээн сүргийн ашиг шим, эдийн засгийн нөөц боломжийг нэмэгдүүлэх.

### ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 1-р зорилтын хүрээнд:

4.1.1 Аймгийн мал аж ахуйн албанд бод мал ялангуяа тэмээн сүргийн талаар мэргэшсэн мэргэжилтэн, сумдын МЭҮТ, нэгжүүдэд малзүйч мэргэжилтэн ажиллуулж тэднийг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах.

4.1.2 Малын үзлэг ангилалтын хашаа, машин техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас, бүртгэлийн маягтаар хангах.

4.1.3 МАА-н мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл орчинг бүрдүүлэх

4.1.4 Малын үржлийн аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх тэдэнд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын үр дүнгээр урамшуулах.

4.1.5 Тэмээн сүргээ тогтвортой өсгөсөн, чанар, ашиг шим, орлогоо нэмэгдүүлсэн сум, багийн удирдлага, мэргэжилтнүүдийн дунд болзолт уралдаан зарлаж дүгнэх, шагнаж урамшуулах

4.2 2-р зорилтын хүрээнд:

4.2.1 Ламын гэгээний улаан тэмээтэй сумдад малын үзлэг ангилалтыг жил бүр хийж үржил ашиг шимийн бүртгэл, судалгааг цэгцлэх.

4.2.2 Тэмээний ашиг шимийн гарцыг тухай бүр шинэчлэн тогтоож малчдын санаачилга дэмжлэгийн үндсэн дээр үржлийн цөм сүрэг зохион байгуулах ажлыг эхлүүлнэ.

4.2.3 Үржлийн хэсэг болгохоор бүрдүүлсэн тодорхойлолт материалыг үргэлжлүүлж ноос, сүү, махны хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үржил селекцийн ажлыг системтэй зохион байгуулна.

4.2.4 Тэмээний зүсийг жигдрүүлж уламжлагдаж ирсэн улаан зүсийг хадгалахын тулд улаан буур, сүүн ашиг шим өндөртэй ингэний төлөөр буур тавихад анхаарна.

4.2.5 Тэмээний тоо толгойг тогтвортой өсгөхийн тулд тухайн жилд бойжуулсан ботгоноос ихгүйгээр зарлага гаргах, зүй бус хорогдлыг багасгах.

4.2.6 Мал эмнэлгийн ажил үйлчилгээнд бүрэн хамруулах.

4.2.7 Тэмээн сүргийн хариулга маллагаа, отор нүүдлийг зөв зохион байгуулж, хашаа хороо, худаг ус, бэлчээр нутгаар хангах.

4.2.8 Төлтэй ингэ бүрийг саалинд, бага насны тэмээг уналга эдэлгээнд хамруулах, аялал жуулчлал хөгжүүлэх, тэмээчдийн баяр, өдөрлөг, уралдаан тэмцээнийг тогтмолжуулах, мал сүргээ морь, тэмээгээр хариулах.

4.2.9 Сум, бүс нутгийн онцлогыг харгалзан ашиг шимийн гол чиглэлээр сүүний, ноосны, галбир бие цогцос, хурдны чиглэлээр удам бий болгоно.

4.2.10 Үржлийн малын үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулах, гойд ашиг шимт мал шалгаруулах.

4.2.11 Ламын гэгээний улаан буурыг бүс нутагтаа сайжруулагчаар ашиглах, бусад сум малчдын захиалгаар нийлүүлэх, солилцох ажлыг мэргэжилтний хяналтан дор явуулах, шаардлагатай нөхцөлд бусад үүлдрийн сайжруулагч оруулж ирэх.

4.3 3-р зорилтын хүрээнд:

4.3.1 Ингэний ферм байгуулах, сүү цагаан идээ боловсруулах үйлдвэр цехийн тоог нэмэгдүүлэх.

4.3.2 Тэмээний ноосонд анхан шатны боловсруулалт хийж зах зээлд нийлүүлдэг болох.

4.3.3 Хилийн худалдаа, дотоод гадаадын зах зээлд ингэний хоормог, цагаан идээ тэмээний гаралтай бусад бүтээгдэхүүнийг нийлүүлж малчдын орлогыг нэмэгдүүлэх.

4.3.4 Улаанбаатар хот болон томоохон суурингуудад нэрийн дэлгүүр, худалдааны сүлжээтэй болох.

4.3.5 Тэмээчдийн зөвлөгөөн, баяр, өдөрлөг, үзэсгэлэн худалдаа, гойд ашиг шимт мал шалгаруулах арга хэмжээг дотоод гадаадын жуулчдын урсгал, тэдний захиалга сонирхолд нийцүүлэх.

4.3.6 Ингэний сүү, цагаан идээний чанар ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, эмчилгээний сувилал ажиллуулах, чанарыг алдуулахгүй удаан хадгалах нөхцөл бүрдүүлэх, хаяг, сав баглаа боодлыг сайжруулах

4.3.7 Мал хариулах, ойр зуурын тээвэр, нүүдэл хийх, баг сум хооронд зорчиход ердийн хөсөг ашигладаг болж шатахууны зардлыг хэмнэх.

## ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1 Аймгийн түвшинд ХХААГ, холбогдох мэргэжилтнүүд

5.2 Сум орон нутгийн хэжээнд сумын Засаг дарга, Тамгын газар, МЭҮТ, нэгж, холбогдох мэргэжилтнүүд

5.3 Стратегийн дагуу 1-5 жилийн төлөвлөгөө гаргаж мал аж ахуй, үржлийн чиглэлийн төрийн болон хувийн хэвшил, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагатай ажил төрлөө уялдуулж ажиллана.



## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭХ ҮР ДҮН

6.1 Тэмээний тоо толгой жил дараалан тогтвортой өсөж ээлжийн ингэнээс 90-с доошгүй хувиар ботго бойжуулна. Жилд дунджаар 4 мянга орчим тэмээгээр өснө гэж тооцоход 10 жилийн дараа аймаг 90 мянга, Ламын гэгээний улаан тэмээ 60 орчим мянгад хүрнэ.

6.2 Аймаг, сумын МАА-н алба, тасаг нэгжийн чадавх сайжирч мал үржлийн нэгжийн тоо 10-аас доошгүйд хүрнэ.

6.3 Малын үржлийн ажилд шаардагдах машин техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр хангагдаж мэргэжилтнүүдийн тогтвортой ажиллах орчин нөхцөл бүрдсэн байна.

6.4 Тэмээний үржил селекцийн ажил төлөвлөгөөний дагуу тасралтгүй чанартай хийгдэж ашиг шим, бүс нутгийн онцлогт тохирсон 3-аас цөөнгүй удам бий болгосон байна.

6.5 Тэмээн сүргийн ноос, сүүн ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх, хаягдалгүй ашиглах, зах зээлд борлуулах, орон нутагтаа анхан шатны тордолт хийх, боловсруулах үйлдвэр цех байгуулах зэргээр малчдын орлогыг өнөөгийн түвшингээс 20-иос доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна.

6.6 Ботготой ингэ бүрийг саалинд, эр тэмээг уналга эдэлгээнд сургах, аялал жуулчлалд ашиглах, үржлийн малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, гойд ашиг шимт мал шалгаруулах, тэмээчдийн зөвлөгөөн, уралдаан тэмцээнийг тогтмолжуулна.

## ДОЛОО. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

7.1 Улс орон нутгийн төсөв

7.2 Хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгө

7.3 Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө Төсөл хөтөлбөрийн хөрөнгө

7.4 Малчид иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгө